



**“БУЛИГААР” ХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт I/</i>	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа</i>	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Булигаар” ХК УБГД: 9010001072 MSE: MBG Утас: 99190037 И-мэйл: info@buligaar.com
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Арьс шир боловсруулалт Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	“Сэрэлт дөл аудит” ХХК 2019-08-28
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	400,212,000
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч У.Цолмон ТУЗ-ийн нарийн бичиг Н.Ууганцэцэг Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Анхболд
1.	<i>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>

	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн: 12,989,285,959,81 Эргэлтийн бус хөрөнгийн дүн: 19,372,522,234.46 Нийт хөрөнгийн дүн: 32,361,808,194.27 Өр төлбөрийн нийт дүн: 20,634,263,291.41 Эздийн өмчийн дүн: 11,727,544,902,86 Өр төлбөр ба эздийн өмчийн дүн: 32,361,808,194.27
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 8,537,653,532.34 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: 6,642,335,869.76 <b>Нийт ашиг:</b> 1,895,317,662.58 Бусад орлого: 8,055,287.43 Бусад зардал: 2,733,071,920.61 Татвар төлөхийн өмнөх ашиг: -2,319,047,078,26 Орлогын татварын зардал: 42,949,132,26 Тайлант үеийн цэвэр ашиг: -2,361,996,210.50
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 6,492,333,619,52 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 6,473,162,001,08 2022 оны тайлант үеийн цэвэр ашиг: -2,361,996,210.5 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл: 13,719,193,359,37
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн: 8,399,131,388,54 Мөнгөн зарлагын дүн: 6,707,654,172.12 Үндсэн үйл ажиллагааны Мөнгөн гүйлгээ 1,694,213,382,42 Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн: Мөнгөн орлогын дүн: 5,000,000 Мөнгөн зарлагын дүн: 1,530,997,815,89 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн: -214,721,843,55 Цэвэр мөнгөн гүйлгээ: 6,639,569.54 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл: 18,353,415.23 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл: 24,992,984,77
1.1.	<b>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</b>	
	<p>“Сэрэлт дөл аудит” ХХК нь “Булигаар” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ. “Булигаар” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	

1.2.	<b>Аудитын тодорхойлох захидал</b> /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийгддэг аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан. Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.	
2.	<b>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</b>	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд <b>Ашигт ажиллагаа</b>
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) -7.2% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) -20% <b>Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</b> Нийт активын өөрчлөлт 66.1% Зээлийн багцын өөрчлөлт 1% <b>Хөрөнгөд эзлэх хувь</b> Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө -7.3% Өр төлбөр /Нийт хөрөнгө 63.8% <b>Хөрвөх чадварын харьцаа</b> Хөрвөх чадварын хөрөнгө/ Татан төвлөрүүлсэн хөрөнгө 102%
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Цар тахал, хил гаалийн үйл ажиллагаа болон Украин улсад үүссэн дайны үйл явдлын нөлөөллөөс үүдэн химийн материалын үнэ өсөх, инфляц, гадаад валютын ханш өсөх, төгрөгийн ханш сулрах эрсдэлийн нөлөөлөл байсан. Гэсэн хэдий ч бидний зүгээс дотоод, гадаад борлуулалтыг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт хийсний үр дүнд бид нийт 15 сая дм квадрат буюу 65 мянга гаруй ширхэг үхрийн арьсыг гүйцэт боловсруулсан финиш хэлбэрээр үйлдвэрлэж дотоодын зах зээлд амжилттай зарж борлуулжээ.  Гадаад борлуулалтын хувьд 2022 онд бид 230 гаруй мянган ширхэг ямааны түүхий эд боловсруулснаас нийт 175 мянган ширхгийг нь хагас боловсруулан экспортолж, орчин цагийн Монголын арьс ширний салбарын түүхэнд түүчээлэгч нь болж 23,000 ширхэг ямааны арьс болон 4500 ширхэг үхрийн арьсыг анх удаагаа бүрэн боловсруулж краст хэлбэрээр экспортод гаргасан.

		<ul style="list-style-type: none"> <li>- Компанийн боловсруулан үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах дотоодын арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг өөрсдийн үйлдвэрлэсэн арьс ширээр хангах зорилготойгоор арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарт зориулж уламжлал ёсоор 4 дэх жилдээ “Leather partners 2022” арга хэмжээг 2022 оны 10 дугаар сард зохион байгууллаа. Энэ удаад арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 100 гаруй аж ахуй нэгж, хувиараа бизнес эрхлэгчид оролцсоноор онцлог байв.</li> <li>- MNS 6561:2015 стандартыг хангасан Үйлдвэрийн дэргэдэх урьдчилан цэвэрлэх байгууламжийн ажил бүрэн дуусаж ашиглалтад орсон.</li> <li>- Италийн алдарт Mosconi брэндийн хуваах машин шинээр авч суурилуулсан.</li> <li>- БНХАУ-аас Young Pearl брэндийн махлах машин шинээр авч суурилуулсан.</li> <li>- Нэг дор 800 өрөөл үхрийн арьс хатаах хүчин чадал бүхий агаарын гинжин хатаалга авч суурилуулсан.</li> <li>- Будгийн барабанд нэмэлт өөрчлөлт хийж засаж тохируулан хүчин чадлыг нэмэгдүүлсэн.</li> <li>- Гүйцэтгэх цехэд Турк улсын Demaksan фирмийн шүрших агрегат машин авч суурилуулсан гэх зэрэг хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж үйлдвэрлэлийн чанар гарцыг нэмэгдүүлэх чиглэлд олон оновчтой хөрөнгө оруулалтуудыг хийжээ.</li> </ul>
2.4.	<p><i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i></p>	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	<p><i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i></p>	2022.12.31-ний өдрийн байдлаар Капитрон банкнаас авсан зээлийн барьцаанд Ү-2206004461 тоот улсын бүртгэлийн дугаартай үл хөдлөх хөрөнгө болон Э-2206003772 дугаартай эзэмших эрхийг газрыг тус тус барьцаасан байгаа. Зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байгаа болно.
3.	<p><b>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</b></p>	
		Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.
4.	<p><b>Цалин урамшууллын мэдээлэл</b></p>	
		2022 онд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд 3 сая төгрөгийн цалинг олгох байгаа.

5. **Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

**2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ**

Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав.

**Хурлын ирц:** Хуралд 88.1 хувийн саналын эрхтэй нийт 5 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан.

**Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр**

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн Буигаар ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөгдсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 100%-ийн саналаар батлав.
- Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулав.
- Компанийн ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулав.
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулж, батлуулав.
- Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.
- Компанийн оноосон албан ёсны нэрийг Булигаар ХК болгож өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэн батлав.
- Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлав.
- Хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох тухай асуудлыг хэлэлцэн батлав.
- Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай тухай асуудлыг хэлэлцэн батлав.
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг танилцуулан, ТУЗ-ийн гишүүдийг 1 жилийн хугацаагаар сонгов.

**2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ**

Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах компанийн өөрийн байранд зохион байгуулагдав.

**Хурлын ирц:** Хуралд 88.1 хувийн саналын эрхтэй нийт 3 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр зохион байгуулагдсан.

**Хурлаар танилцуулан хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр:**

- Компанийн нэмж гүйлгээнд гаргах энгийн хувьцааны тоог 140’000’000 (нэг зуун дөчин сая) хүртэлх байхаар тогтоов.
- Компанийн “Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” (ESOP)-ийг хавсралтаар батлав.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 1 жилийн хугацаагаар сонгов. Үүнд:

- *Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:* Жадамбын Эрдэнэбат, Төмөрбаатарын Болд, Чулуунбаатарын Нямдорж
- *Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:* Батчулууны Анхболд, Анхболдын Энхмэнд, Батчулууны Баянжаргал, Довжидын Гансүх, Мягмарын Төрхүү, Цэрэндагвын Мөнхлхагва

“Булигаар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Компанийн тухай хуулийн хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, компанийн стратегийн зорилтот түвшин, санхүү эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөг батлан, холбогдох чиг үүрэг, зөвлөмжүүдийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.

Дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороог ажиллуулж, засаглалын болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан, ирц:** Төлөөлөн удирдах зөвлөл нь 80-100 хувийн ирцтэйгээр 13 удаагийн хуралдаанаар 23 тогтоол, 13 тэмдэглэлээр шийдвэр гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. ТУЗ-ийн хурлыг танхимаар, цахимаар, эчнээгээр зохион байгууллаа.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

**Цалин урамшууллын хороо:** Тус хороо нь ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий ажилтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, компанийн хэмжээнд цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь ТУЗ-д туслахад оршино.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат

Гишүүд: ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Гансүх  
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Баянжаргал  
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Мөнхлхагва

Тайлант хугацаанд 2 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэж, хорооны чиг үүргийнхээ хүрээнд санал, зөвлөмж үүрэг даалгавар өгч ажиллав. Үүнд:

- ТУЗ-ийн 2021 оны зардлын гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөл хэлэлцэх;
- Компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм журмуудыг шинээр болон шинэчлэн батлах;

**Аудитын хороо:** Тус хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн, дотоод хяналт, үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага хэрэгжилт, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар ТУЗ-ийг хяналтын чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилласан.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Нямдорж

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Болд

ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Анхболд

ТУЗ-ийн ердийн гишүүн М.Төрхүү

Тайлант хугацаанд 100 хувийн ирцтэйгээр 3 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэж, хорооны чиг үүргийнхээ хүрээнд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагуудад санал, зөвлөмж үүрэг даалгавар өгч ажиллав. Үүнд:

- Компанийн 2021 оны санхүүгийн тайлан болон аудитын зөвлөмжийг хэлэлцэх;
- Компанийн найдваргүй авлагын тухай хэлэлцэх;
- Компанийн үндсэн хөрөнгийг бүртгэлээс хасах тухай хэлэлцэх;
- Компанийн 2022 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн тайлантай танилцах;
- Компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм журмуудыг шинээр болон шинэчлэн батлах;

**Нэр дэвшүүлэх хороо:** компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах бодлого журмыг боловсруулах тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр хяналт, удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Болд

Гишүүд: ТУЗ-ийн дарга А.Энхмэнд

ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Мөнхлхагва

Тайлант хугацаанд 2 удаа хуралдаж доорх асуудлуудыг хэлэлцэж, хорооны чиг үүргийнхээ хүрээнд санал, зөвлөмж үүрэг даалгавар өгч ажиллав. Үүнд:

- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах;
- Компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодекст нийцүүлэх ажлын хүрээнд холбогдох дүрэм журмуудыг шинээр болон шинэчлэн батлах;

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаанд 108,836,600 төгрөгийн зардал (2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02/22 тоот тогтоолоор батлагдсан.) төлөвлөж, гүйцэтгэл 64,931,850 төгрөг буюу 59.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

<i>Зардлын төрөл</i>	<i>Төлөвлөгөө</i>	<i>Гүйцэтгэл</i>
ТУЗ-ийн цалин урамшуулал	3,000,000	3,000,000
ХЭ-ийн хурлын зардал /2 удаа/	1,861,600	2,504,900
Бусад зардал /Үйлчилгээний хураамж/	3,975,000	6,964,950
Хувьцаа хуваах, гаргах	100,000,000	52,462,000
<i>/Зөвлөх үйлчилгээний төлбөр, бусад/</i>		
<b>Нийт дүн</b>	<b>108,836,600</b>	<b>64,931,850</b>

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮН

#### 1. Батчулуун АНХБОЛД

##### *Боловсролын талаарх мэдээлэл*

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1995	1996	Мэдээлэл зүйн магистр
2	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1990	1994	Худалдааны эдийн засагч

##### *Мэргэжил дээшлүүлсэн байдал*

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0730592	2016/03	Компанийн засаглал

##### *Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	Гүйцэтгэх захирал	2019 - одоо
2	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
3	Дархан Минж ХХК	Ерөнхий захирал, Гүйцэтгэх захирал	2001 - 2018
4	Санком ҮЦК ХХК	Диллер	1998 - 2000
5	Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн сургууль	Мэдээлэл зүйн багш	1994 - 1996

#### 2. Батчулуун БАЯНЖАРГАЛ

##### *Боловсролын талаарх мэдээлэл*

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Монгол Улсын Их сургууль	Улаанбаатар	1996	2000	Эдийн засагч

##### *Мэргэжил дээшлүүлсэн байдал*

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал

##### *Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл*

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
2	Дархан Минж ХХК	Гүйцэтгэх захирал, дэд захирал	2006 - одоо
3	Монгол шуудан банк	Нягтлан бодогч	2000- 2006

#### 3. Анхболд ЭНХМЭНД

##### *Боловсролын талаарх мэдээлэл*

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Вестминстерийн Их сургууль	ИБУИНВУлс, Лондон хот	2013	2016	Хөрөнгө оруулалтын Санхүүч



**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230359	2019/06	Компанийн засаглал
2	Санхүүгийн зохицуулах хороо		2018	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Лугати ХХК	Гүйцэтгэх захирал	2020 - одоо
2	Булигаар ХК	ТУЗ-ийн дарга	2019 - одоо
3	Екап ХХК	Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал	2018 - 2019
4	Монгол шир төсөл, Парк таун бонд	Санхүүгийн зөвлөх	2018
5	Ард секюритиз УЦК ХХК	Хөрөнгө оруулалтын аналит	2017
6	Монголын үнэт цаасны бирж ХХК	Төлбөр тооцооны ахлах ажилтан	2016 - 2017

**4. Довжид ГАНСҮХ****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	Барилгын Их Сургууль	ОХУ-лс, Эрхүү хот	1986	1991	Барилгын технологич

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын үндэсний төв	0230360	2019/06	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	ТУЗ-ийн ердийн гишүүн	2019 - одоо
2	Булигаар ХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал	2019 - одоо
3	Сүлд Ивээл Констракшн ХХК	Захирал	2014 - 2018
4	Дархан Минж ХХК	Үйлдвэрлэл хариуцсан захирал, Үйлдвэрлэлийн менежер	2004 - 2013
5	Зэндмэнэ инвест ХХК	Захирал	1995 - 2004

**5. Мягмар ТӨРХҮҮ****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС-ийн Эдийн засгийн сургууль	Улаанбаатар	2006	2010	Нягтлан бодох бүртгэлийн магистр
2	Шинжээч НЭЗДСургууль	Улаанбаатар	1996	2000	Нягтлан бодох бүртгэл

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийнндэсний төв		2022/03	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигар трейд ХК	Гүйцэтгэх захирал	2021 - одоо
2	Мон-Ит Булигаар ХК	Ерөнхий нягтлан бодогч	2020 - 2021
3	АПУ ХК	Нягтлан бодогч	2019 - 2020
4	Баянгол дүүргийн Татварын хэлтэс	Татварын байцаагч	2013 - 2016
5	Налайх дүүргийн Татварын хэлтэс	Татварын байцаагч	2010 - 2013
6	Дархан минж ХХК	Нягтлан бодогч	2005 - 2010
7	Цээнээ ХХК	Нягтлан бодогч	2000 - 2004

**6. Цэрэндагва МӨНХЛХАГВА****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС, КтМСургууль	Улаанбаатар	2001	2005	Бизнесийн удирдлага
2	ШУТИС, КтМСургууль	Улаанбаатар	2006	2007	Хүний нөөцийн менежментээр магистр

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв		2022/03	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Булигаар ХК	Хүний нөөцийн ахлах менежер	2019 - одоо
2	ТМГрупп ХХК	Хүний нөөцийн зөвлөх	2016 - 2018
3	Алтайн хүдэр ХХК	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	2008 - 2016
4	Гангар Инвест ХХК	Хүний нөөцийн менежер	2007 - 2008

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН****7. Жадамба Эрдэнэбат****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн он	Төгсөн он	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС	Улаанбаатар	1987	1992	Математикч

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0630111	2013/03	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	МУИС, ТИС	Багш	1992-1995
2	Ноёнуудал брокерийн пүүс	Гүйцэтгэх захирал	1996 - 2001
3	Ханын материал ХК	Санхүү эрхэлсэн захирал	2002 - 2004
4	Хөдөө аж ахуйн бирж	Гүйцэтгэх захирал	2013 - 2016
5	Монголын Үнэт цаасны бирж	Гүйцэтгэх захирал	2017 – 2020
6	Эрдэс баялгийн бирж	Гүйцэтгэх захирал	2020- хойш

**8. Төмөрбаатар БОЛД****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	ЗХУ Украин Машин байгууламжийн дээд	Луганск	1987	1992	Инженер

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0430482	2017/03	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Монголын хөрөнгийн бирж	Хяналтын ажилтан	1992-1995
2	Дэлгэрхангай брокерийн пүүс	брокер	1995 - хойш
3	Даац инвестмент ХХК	Гүйцэтгэх захирал	2017 - хойш

**9. Чулуунбаатар НЯМДОРЖ****Боловсролын талаарх мэдээлэл**

№	Төгссөн сургууль	Байршил	Элсэ н он	Төгсө н он	Эзэмшсэн мэргэжил
1	ХААИС	Улаанбаатар	1988	1992	ХАА-н нягтлан бодогч эдийн засагч
2	МУИС	Улаанбаатар	1997	2000	Эрх зүйч
3	ХААИС	Улаанбаатар	2003	2003	Бизнесийн удирдлагын магистр

**Мэргэжил дээшлүүлсэн байдал**

№	Сургууль, дамжаа, курс	Дугаар	Огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	0430968	2022/03	Компанийн засаглал

**Ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл**

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	ШУА-ын харьяа ХАА-н Эдийн засгийн хүрээлэн	Эрдэм шинжилгээний ажилтан	1992 - 1993
2	Чингэлтэй дүүргийн Татварын алба	ТУБ	1993 - 1995
3	Төрийн хянан шалгах хороо, Нийслэлийн аудитын газар	Хянан байцаагч, ахлах хянан байцаагч, ахлах шинжээч	1995 -2014
4	Одбүртгэл аудит болон Мүүрь Аудит ХХК	Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан дэд захирал	2014 хойш

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

*Гүйцэтгэх захирал Б.Анхболд*

*Үйлдвэрлэл хариуцсан захирал Д.Гансүх*

*Ерөнхий нягтлан бодогч У.Цолмон*

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ КОДЕКС

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсаны дагуу “Булигаар” ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд үе шаттайгаар компанийн засаглалын бодлого, дүрэм журмуудыг кодексст нийцүүлэх ажлыг хийхээр төлөвлөсөн. Үүний хүрээнд “Булигаар” ХК-ийн ТУЗ-аас дараах журам болон баримт бичгүүдийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

- ТУЗ-ийн 2022 оны 5-р сарын 04-ний өдрийн 08/22 тоот тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баталсан.
- ТУЗ-ийн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 20/22 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмуудыг баталсан. Үүнд:
  1. Аудитын хорооны үйл ажиллагааны журам
  2. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
  3. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
- Мөн 2022 оны 10-р сарын 14-ний өдрийн 21/22 тоот тогтоолоор Булигаар ХК-ийн бодлогын баримт бичгүүдийг баталсан. Үүнд:
  1. Ногдол ашгийн бодлого
  2. Залгамж халааны бодлого
  3. Цалин, урамшууллын бодлого
  4. Комплайнсын хяналтын бодлого
  5. Дотоод хяналтын бодлого
  6. Дотоод аудитын бодлого
  7. Эрсдэлийн удирдлагын бодлого
- ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын 16-ны өдрийн 23/22, 24/22 тоот тогтоолуудаар дараах журмуудыг баталсан. Үүнд:
  1. Ёс зүйн дүрэм
  2. Шүгэл үлээх журам
  3. Мэдээлэл хүргэх журам
  4. ТУЗ-ийн гишүүдэд танилцуулга хийх

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндлэх бөгөөд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, баримтлах стратегийн бодлогын бичиг баримтыг 2023 оны 2-р улиралд багтаан баталж, хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Одоогоор оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд компанийн ёс зүйн дүрэм болон шүгэл хүлээх журмыг батлан мөрдөж, ажиллаж байгаа.

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ**

Компани нь сайн засаглалын туршлагаудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч байгаа.

2022 оны байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төлөвлөгөөт хугацаанд нь зохицуулагч байгууллагууд руу илгээн тайлагнасан бөгөөд улирал тутмын үйл ажиллагааны тайланг МХБ-тэй хамтран олон нийтэд танилцуулан тайлагнасан.
- 2021 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2022 оны 1, 2, 3-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан;
- 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал (139 хуудас материал, 1 ном)-ыг 2022.04.22-ны өдөр СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнасан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулсан тайлан материал (139 хуудас материал, 1 ном)-ыг 2022.09.26-ны өдөр СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнасан.
- Санхүүгийн зохицуулах хорооноос 2022.03.22-ны өдөр “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан бөгөөд тус шинэ кодексийн дагуу хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэн 2022.06.30-ны өдөр СЗХ руу илгээсэн.

2022 оны Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан 2023.01.31-ний өдөр СЗХ болон МХБ рүү цахимаар илгээсэн.

**6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл**

Байхгүй.

**7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/**

Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 400,212,000 үүнээс 5 ба түүнээс дээш хувийг 3 хувьцаа эзэмшигч буюу 88.11%-ийг дараах нэр бүхий хувьцаа эзэмшигчид нь эзэмшдэг болно. Үүнд:

<i>Нэр</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Хувь</i>
А.Энхмэнд	156,630,000	39.14%
Б.Анхболд	145,996,000	36.48%
Б.Баянжаргал	50,000,000	12.49%
Бусад 721 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%
<b>Нийт дүн</b>	<b>400,212,000</b>	

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно.

**8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл**

2022 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй.

**9. Ногдол ашгийн мэдээлэл**

**2021 оны ногдол ашиг тараалт**

Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 02 тоот тогтоолоо нэгж хувьцаанд 600 төгрөг хуваарилахаар шийдвэр гаргасан. Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож 2022 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгохоор ногдол ашиг зуучлуулан тараах гэрээний дагуу нийт 687 хувьцаа эзэмшигчийн дансанд 47,586 ширхэг хувьцаанд ногдох 26,739,030 төгрөгийг байршуулсан. 5-аас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу компаниас 3 хувьцаа эзэмшигчид ногдол ашигт ногдох мөнгийг олгосон.



№	Ногдол ашиг тараах эрх бүхий байгууллага	Хувьцаа эзэмшигчдийн тоо	Хувьцааны тоо ширхэг	Албан татвар суутгагдсаны дараа олгосон мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	687	47,586	26,739,030
2	Булигаар ХК	3	352,626	190,418,040
<b>Нийт тараасан ногдол ашиг</b>		<b>690</b>	<b>400,212</b>	<b>240,127,200</b> <i>/албан татвар суутгаагүй дүн/</i>


10. **Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл**

1. Үйлдвэрийн дэргэдэх Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нь хоногт 150 м3 үйлдвэрийн хаягдал усыг Монгол Улсын MNS:4943-2015 стандартын түвшинд хүргэж цэвэршүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой. Шинээр баригдсан цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг 2021 онд хийж гүйцэтгэсэн. Цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулгын ажлыг 2022 оны 02-р сарын 25-ний өдрөөс 03 сарын 07 өдрийг хүртэл нийт 11 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхийн хамт тус цэвэрлэх байгууламж дээр ажиллах ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх, дадлагажуулах ажлыг дурдсан хугацаанд хийсэн болно. Цэвэрлэх байгууламж нь бохир усыг физик болон химийн аргаар цэвэрлэх, лаг усгүйжүүлэх гэсэн үндсэн хоёр технологийн дагуу ажиллана.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” болгон зарласан тул энэ өдрөөр байгаль орчноо хамгаалах үзлийг түгээн дэлгэрүүлэх, мод тарих хөдөлгөөнийг бүх нийтээр өрнүүлдэг билээ. Энэхүү ажлын хүрээнд манай компанийн нийт ажилтнуудын оролцоотойгоор компанийн ойр орчимд 500 гаруй хайлаас мод тарьж, 260 гаруй м.кв-ыг зүлэгжүүлэн ногоо байгууламжийг бүрдүүлэв.  
Энэхүү ногоон байгууламжийг амжилттай тариалснаар байгаль орчинд эергээр нөлөөлөхийн зэрэгцээ тухайн хэсгийн талбайн хөрсийг хамгаалж элэгдэл эвдрэлд өртүүлэхгүй байх, тоосжилт үүсэхээс сэргийлэх, ургамлан нөмрөгийг тогтворжуулах, агаар цэвэршүүлэх, агаарын бохирдлыг багасгахад нөлөөлөх, өвлийн цагт цасыг сайн хуримтлуулах зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ач холбогдолтой.  
Булигаар ХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдлээ.

3. Нийт ажилтнуудын эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх зорилгоор компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил тутам хамруулдаг. 2022 онд СХД-ийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 70 гаруй ажилтанг үзлэг шинжилгээнд хамруулсан. 2023 онд үзлэгт хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үзэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

<p>Овог, нэр: Б.Анхбаатар JSC          Албан тушаал: "Булигаар" ХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p> <p>(Тамгатамдээ)</p>	<p>Овог, нэр: Д. Айтманын          Албан тушаал: "Сэрэлт дөл аудит" ХХК аудитын компанийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: </p>
--	--

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 

Овог, нэр: У.Цолмон  
 Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч  
 Гарын үсэг: 

Овог, нэр: Н.Ууганцэцэг  
 Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичиг  
 Гарын үсэг: 